



ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 1/23

Жаргалтхаан сум

Дээрэлхэлтийг бууруулах, таслан зогсоох
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.2 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн ахлагч: Д.Бямбадорж – бага ангийн багш

Гишүүд: Г.Лхагвадулам - математикийн багш

Э.Хишигсүрэн – бага ангийн багш

А.Мөнхбат - математикийн багш

Л.Дархисүрэн - бага ангийн багш

Г.Цэгмид – номын санч

2. Хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, холбогдсон болон хохирогч суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, “Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхэд дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөл (Д.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЧИНБАТ



D/Tushaal-2024
232401043